БАТЛАВ.
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.БАЯРБАТ

“ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦ. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА” /БНбД 21-07-14/ БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМД ДҮН ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА ХИЙЖ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 05/2024

Улаанбаатар хот

Төсөл боловсруулах үндэслэл	Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйл 33.1.2 дугаар заалт; Улсын Онцгой Комиссын 2024 оны 4 дүгээр хурлын шийдвэр; Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлсан “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо”; Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2024 оны төлөвлөгөөний Б-2-1-ийн 7.5 заалт.
Төслөөр шийдвэрлэх асуудлууд	“Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм” /БНБД 21-07-14/ барилгын норм ба дүрэмд дүн шинжилгээ судалгаа хийх, шатахуун түгээх станцын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, сэргээн засварлах, их засвар хийх зураг төсөл зохиоход мөрдөх норматив баримт бичигт Улсын Онцгой Комиссын 2024 оны 4 дүгээр хурлын шийдвэрийн дагуу “Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм” /БНбД 21-07-14/ Барилгын норм ба дүрмийн 5.8 дахь заалт буюу аюулгүйн зай хэмжээсийг тэсэрч дэлбэрэх аюултай бодис ямар зайд, хэрхэн хор хөнөөл учруулж болзошгүй талаар шинжлэх ухааны үндэслэл, судалгаатай 2-оос 3 орны жишээ тооцоо оруулах, 19.1 дэх заалтад өөрчлөлт оруулж, шатахуун түгээх станц авто машин хийгээр цэнэглэх станцыг тусдаа байхаар зохицуулж, хэрэгжилтийг хангуулах, мөн 7 дугаар хүснэгтэд шингэрүүлсэн нүүрс устөрөгчийн хийтэй бол орон сууц олон нийтийн барилга байгууламжаас 60 метр, “Хийн хангамж” БНбД /42-01-19/ нормын 22 дугаар хүснэгтэд ил савтай 10 м.куб бол 18 метр гэж зөрүүтэй заалтыг нийцүүлж, өөрчлөлт оруулна.
Төслийн бүрдэл	1. Хэрэглэх хүрээ; 2. Норматив эшлэл; 3. Нэр томьёо, тодорхойлолт; 4. Тэмдэглэгээ ба товчлол; 5. Шатахуун түгээх станцуудын ангилал;

	6. Ерөнхий шаардлага; 7. Шингэн хөдөлгүүрт түлш цэнэглэх станцад тавигдах нэмэлт шаардлага; 8. Хийн хөдөлгүүрийн түлшээр ажилладаг шатахуун түгээх станцад тавигдах нэмэлт шаардлага; 9. Галын хаалтын төрлийг сонгох; Хавсралт А. Нэг ханатай савны битүүмжлэл эсвэл хоёр ханатай сав, дамжуулах хоолойн хана хоорондын зайг хянах системүүд; Хавсралт Б*. Газар дээрх нэг ханатай савыг ашиглахыг шаарддаг шингэн мотрт түлшээр ажилладаг шатахуун түгээх станцуудад тавигдах тусгай шаардлага; Хавсралт В*. Шингэн хөдөлгүүрт түлш цэнэглэх станцад тавигдах тусгай шаардлага; Хавсралт Д*. Хөдөлгөөнт шингэн хөдөлгүүрт түлш цэнэглэх станцад тавигдах тусгай шаардлага; Хавсралт Е*. Хийн хөдөлгүүрийн түлшээр цэнэглэх станцад тавигдах тусгай шаардлага; Хавсралт Ё*. Нэг ханатай LPG хадгалах сав бүхий хий дүүргэх станцад тавигдах тусгай шаардлага; Хавсралт Ж*. Суултын янданд LNG савтай криоген шатахуун түгээх станцад тавигдах тусгай шаардлага; Хавсралт З*. Зөөврийн автомашины крио шатахуун түгээх станц, хийн дүүргэлт, хий цэнэглэх станцад тавигдах тусгай шаардлага.
Төслийг хэрэгжүүлэгч байгууллага	Барилга, хот байгуулалтын яам; "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ
Төслийг гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэгчийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу сонгон шалгаруулна.
Төслийн боловсруулж дуусгах хугацаа	2025 оны IV улирал
Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ	Урьдчилсан тооцоогоор нийт 24,355,000 төгрөгийг "Барилга байгууламжийн норм, нормативын сан"-аас санхүүжүүлнэ.
Онцгой нөхцөл	- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо"-ны шаардлагыг хангасан байна. - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 98 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-тай уялдуулан шинэчлэн боловсруулна.

	- Техникийн даалгаврын төслийн бүрдэлд тусгагдсан агуулгатай байхаас гадна боловсруулалтын явцад төслийг ойлгомжтой, эмх цэгцтэй, нэмэлт мэдээлэл тусгагдахаар сайжруулалт хийх тохиолдолд захиалагчийн зөвшөөрлөөр өөрчлөлт орж болно. - Боловсруулагдаж байгаа баримт бичигтэй холбоотойгоор Монгол улсын барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичиг, стандартын давхцалтай болон зөрүүтэй ойлголтыг засварлах саналыг захиалагчид зөвлөмж байдлаар ирүүлэх. Мөн дээр дурдсан баримт бичигт хүчингүй болгох заалтын талаар зөвлөмж ирүүлэх. - Суурь материалд СП 156.13130.2014 "Станции автомобильные заправочные. Требования пожарной безопасности"-г эх материал болгон боловсруулалт хийнэ.

"ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦ. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА" /БНбД 21-07-14/ БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМД ДҮН ШИНЖИЛГЭЭ СУДАЛГАА ХИЙЖ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨВ

-	Хийх ажлын нэр	Хөдөлмөр зарцуулалт /хүн, өдөр/			Шаардагдах зардал /төгрөг/	Хянасан
		Ажиллах хүн/өдөр	Нэгж хүн өдрийн үнэлгээ /төгрөг/	Зөвлөх багт ажиллах хүний тоо		
1	Олон улсад хэрэглэгдэж байгаа энэ төрлийн норматив баримт бичгийг судалж, танилцан үнэлэлт дүгнэлт гаргах	15	117,800	1	1,767,000	
2	Судалгааны материалын үр дүнг цэгцэлж, эх материалыг судлах, Монгол хэлнээ хөрвүүлэх	20	117,800	2	4,712,000	
3	Хөрвүүлсэн ажлыг цэгцлэн бусад норматив баримт бичигтэй уялдуулан боловсруулах	25	117,800	2	5,890,000	
4	Боловсруулсан төслийг захиалагчийн шаардлагыг хангах түвшинд хянаж, төслийг бэлтгэж ирүүлэх	18	117,800	1	2,120,000	
Гүйцэтгэгчид олгох нийт мөнгөн дүн /төгрөг/					**14,489,000**	

5	Нормын төслийг хянан тохиолдуулах	22	117,800	1	2,591,600	
6	Нормын төсөлд шүүмж хийх	20	117,800	1	2,356,000	
7	Холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх зардал	-	-		1,000,000	
8	Салбарын шинжлэх, ухаан, техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх зардал	-	-	-	1,375,000	
9	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ажлыг эхлүүлэх зардал	-	-	-	200,000	
10	Боловсруулсан төсөлд дүгнэлт гаргах /Ажлын хэсэг/	-	-	-	3,311,400	
Бүгд /төгрөг/					**10,834,000**	
Бичиг хэргийн зардал 1.5% /төгрөг/					210,000	
НИЙТ ӨРТӨГ					**24,355,000**	

Тайлбар: Зөвлөхөд олгох 1 хүн өдрийн хөлсийг Үндэсний Статистикийн хорооны мэдээллээр 117,800 төгрөгөөр тооцов.

ХЯНАСАН:

БХБЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА-г Д.ГАНТУЛГА

БХБЯ-НЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА Ц.АРИУНСАНАА-г

БХБЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.БАЯРБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”-ИЙН ЗАХИРАЛ Ц.АМАРСАНАА

ТУС ТӨВИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Д.АЛТАНХУЯГ

ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.БАТЖИЛМАА

ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.САРУУЛТУЯА